



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар

А/54

Улаанбаатар хот

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн, гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлуулж, хэрэгжилтийг хангаж, үр дүнг бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс (Х.Азбаяр)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2022 оны А/31 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Ж.Лхагвасүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010289

Чингэлтэй дүүргийн Засаг даргын
2025 оны 03 дугаар сарын 13 өдрийн
144 дугаар захирамжийн хавсралт

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Хүүхдийн эрхийн хууль зүйн
хорооны дарга:

Засаг даргын орлогч

Гишүүд:

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр)

Чингэлтэй дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын албаны
дарга (зөвшилцсөнөөр)

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн
дарга

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн
хэлтсийн дарга

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн
хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга
(зөвшилцсөнөөр)

Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын
Чингэлтэй дүүргийг хариуцсан Шийдвэр гүйцэтгэгч
(зөвшилцсөнөөр)

Чингэлтэй дүүргийн Прокурорын газрын дарга
(зөвшилцсөнөөр)

Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газрын дарга

Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтсийн дарга

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний хэлтсийн дарга

Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга

Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч
(зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Чингэлтэй дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил,
хамгааллын хэлтсийн дарга